



214

МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР ОНӨТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 08 сарын 01 өдөр

Дугаар 7/40

Улаанбаатар хот

Хүний нөөцийн хөгжлийн  
хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээллийн журам"-ын 2 дугаар хэсгийн 2.7.1, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн 99 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.10.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын 2017-2020 онд хэрэгжүүлэх "хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр"-ийг 1 дүгээр хавсралтаар, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар баталсугай.

2. "Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр"-ийг нийт ажилтан, албан хаагчдад танилцуулж, хэрэгжилтийг зохион байгуулан биелэлтэд хяналт тавин ажиллахыг Орлогч дарга /Я.Болдбаатар/-д даалгасугай.

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг жил бүрийн төсөвт тусган шийдвэрлүүлэхийг Нягтлан бодогч /Р.Дашгомбо/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ



"Монгол наадам цогцолбор" орон нутгийн өмчит  
төсөвт үйлдвэрийн газрын даргын 2017 оны 08 сарын  
01-ны өдрийн дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

## "МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР" ОНӨТҮГ-ЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР /2017-2020/

### Нэг. Ерөнхий үндэслэл

1.1. Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын болон Төрийн албаны зөвлөлийн тогтоол шийдвэр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх /цаашид "Хөтөлбөр" гэх/ зорилгоор 2017-2020 онд энэхүү хөтөлбөрийг мөрдөнө.

1.2. Хөтөлбөрийн зорилго нь төрийн зорилт, чиг үүргийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх, төрийн албаны болон байгууллагын өөрчлөлт, хөгжлийн бодлоготой уялдуулан хүний нөөцийн сургалт, хөгжлийн тогтолцоог боловсронгуй болгох, ажилтан, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн үнэт зүйл, мэдлэг чадвар бүхий хүний нөөцийг төлөвшүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

1.3. Хөтөлбөрийг төрийн албаны сургалтын өнөөгийн байдал болон ирээдүйн хэрэгцээ, түүнийг хангахад чиглэсэн сургалтын үр дүн, нөөц, бусад байгууллагад хэрэгжүүлсэн туршлагад тулгуурлан боловсруулав.

### Хоёр. Хөтөлбөрийн зорилтууд

- 2.1. Төрийн албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, мэргэшүүлэх;
- 2.2. Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, таатай орчныг бүрдүүлэх;
- 2.3. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгаа, эрүүл мэндийг хамгаалах, амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх,
- 2.4. Төрийн албан хаагчдыг цалин хөлс, үр дүнгээр нь урамшуулах.

### Гурав. Хөтөлбөрийн санхүүжилт, хугацаа

3.1. Ажилтан, албан хаагчдын сургалтад зориулсан санхүүжилтийг жил бүр "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын төсөвт тусган шийдвэрлэнэ.

3.2. Байгууллагын дотоод нөөц бололцоо бусад Олон улсын зээл тусламж, төсөл хөтөлбөрийн эх үүсвэрийг ашиглана.

3.3. Хөтөлбөрийг 2017-2020 онд хэрэгжүүлнэ.

### Дөрөв. Хөтөлбөрийн хамрах хүрээ

4.1. Хөтөлбөрт "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын нийт ажилтан, албан хаагчид хамрагдана.

### Тав. Хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээ

5.1. Төрийн албан хаагчийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, зорилтын хүрээнд:

5.1.1. Албан хаагчийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг жил бүр батлуулах;



5.1.2. Тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллаж байгаа албан хаагчдаас Удирдлагын академийн 1.5-2 жилийн захиалгат анги, богино хугацааны сургалтад хамруулах;

5.1.3. Дотоод, гадаадын магистрантур болон докторантур, салбарын чиглэлээр аспирантурт суралцах хугацаанд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх;

5.1.4. Төрийн албан хаагч бүрд үндсэн ажлаасаа хөндийрөхгүйгээр өөрийн мэдлэг, мэргэжил, үр чадвараа дээшлүүлэх боломжоор хангах;

5.1.5. Албан хаагчийн дотоодын бакалавр, магистр, докторын мэргэжил дээшлүүлэх сургуульд суралцахад нь байгууллагын зүгээс дэмжлэг үзүүлэх;

5.1.6. Байгууллагын залгамж чанарыг алдагдуулахгүй байх үүднээс ажлын байранд сургаж, дадлагажуулах;

5.1.7. Гадаадын болон нутгийн захиргааны байгууллагуудын ажлын туршлагатай танилцан, тэдний ажлын амжилтаас нь хуваалцах

5.1.8. Нийслэлд шаардлагатай нарийн мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх сургалтад хамруулах

5.1.9. "Сургалтын төлөвлөгөө", "Мэдлэгийн цаг"-ийг тодорхой чиглэл зорилго төлөвлөгөөтэй зохион байгуулах

5.2. Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, таатай орчныг бүрдүүлэх зорилтын хүрээнд:

5.2.1. Төрийн албан хаагчдыг шаардлагатай компьютер, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж бичиг хэргийн материал, ажлын нөхцөлөөр хангах

5.2.2. Интернет, албаны веб сайт, мэдээллийн гадаад, дотоод сүлжээний найдвартай ажиллагаагаар тогтмол хангах

5.2.3. Албаны цэвэр цэмцгэр байдлыг хангаж, өрөө тасалгаанд засвар үйлчилгээг шаардлагатай тохиолдолд хийх

5.2.4. Албаны өрөө тасалгааны агааржуулалт, чийгшүүлэлт, гэрэлтүүлэг, цэцэгжүүлэлт болон тавилгыг шинэчлэх, тохижуулах,

5.2.5. Албаны коридорын хэсгийг иргэдийг хүлээн авах хүлээлгийн танхим, уулзалтын өрөөний стандартад нийцүүлэн тохижуулах

5.2.6. Эрх зүйн холбогдол бүхий шаардлагатай хууль тогтоомж, гэрээ эрх зүйн болон мэргэжлийн чиглэлээр сүүлийн үед хэвлэгдсэн ном сурах бичгийн сан бий болгох

5.2.7. Төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд шаардагдах мэдээллийг тогтмол шуурхай дамжуулах, тэднийг мэдээллээр хангах зорилгоор "Мэдээллийн самбар" ажиллуулах

5.3. Төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа, эрүүл мэндийг хамгаалах амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилтын хүрээнд:

5.3.1. Байгууллагаас орон сууц хүссэн албан хаагчдын өргөдөл хүсэлтийг үндэслэн ажилласан хугацаа, ажлын үр дүн, амьдралын нөхцөл байдал зэргийг харгалзан орон сууцны дэмжлэг үзүүлэх,

5.3.2. Төрийн албан хаагчид орон сууцны зориулалтаар хөнгөлөлттэй зээл олгох төсөлд хамруулах ажлыг зохион байгуулах,

5.3.3. Албан хаагчдын газар өмчлөлийн судалгааг гаргаж, зуслангийн болон хувийн байшин барьж амьдрах сонирхолтой албан хаагчдыг дэмжиж холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх,

5.3.4. Албан хаагчийн ажилдаа ирж, очих унааны хөнгөлөлт үзүүлэх

5.3.5. Жил бүр албан хаагчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулах,

5.3.6. Биеийн тамир, спортын хамтлаг байгуулах, хамтлагийн үйл ажиллагааг идэвхтэй явуулах, жил бүр төлөвлөгөө гаргаж ажиллах,



5.3.7. Албан хаагчдын эрүүл мэнд чийрэгжилтэд анхаарч спорт заалыг бүрэн дүүрэн ашиглаж, уралдаан тэмцээн зохион байгуулах, дасгал хийлгэх зэрэг ажлуудыг зохион байгуулах,

5.3.8. Шинээр гэр бүл болсон болон шинээр хүүхэд төрүүлсэн гэр бүлд санхүүгийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх,

5.3.9. Албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олны уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор амралт зугаалга, байгалийн сайханд аялах, явган аяллыг жил бүрийн хавар, намарт зохион байгуулах,

5.3.10. Төрийн албан хаагчийн өрхийн орлогыг зохих хэмжээгээр нэмэгдүүлэх зорилгоор туслах аж ахуй эрхлэх, ногоо тарихад нь газрын асуудлыг шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх,

5.4 Төрийн албан хаагчдын цалин хөлс, үр дүнгээр нь урамшуулах арга хэрэглүүрийг боловсронгуй болгох зорилтын хүрээнд:

5.4.1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу албан хаагчийн цалин болон нэмэгдлийг жил бүр шинэчлэн тогтоох,

5.4.2. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ажлын үр дүнг үнэлж урамшуулал олгох,

5.4.4. Үйл ажиллагааны үр дүнгийн гэрээний биелэлтийн дүнг үндэслэн зэрэг дэв ахиулах, алгасуулах, цалингийн шатлал нэмэгдүүлэх, төрийн албан хаагчийн холбогдох нэмэгдлүүдийг олгох

5.4.5. Албан хаагчдын албан үүргээ үр дүнтэй биелүүлж, өндөр амжилт гаргасан идэвх зүтгэлийг нь үндэслэн төрийн одон медаль, төрийн албаны тэргүүний ажилтан, Засаг дарга, Иргэдийн хурлын шагнал, Ерөнхий менежерийн өргөмжлөл болон бусад цол тэмдэг, яамны жуух, мөнгөн шагналаар шагнах эд зүйл болон үнэ бүхий зүйл дурсгах,

5.4.6. Жил бүр хүүхдийн баяраар албан хаагчийн 0-16 насны хүүхдэд зориулсан арга хэмжээ зохион байгуулах

5.4.7. Ажил үйлсээрээ тэргүүлсэн албан хаагчийг гадаад, дотоодын дурсгалт газруудаар аялуулах ажлыг зохион байгуулах

5.4.8. Жил бүрийн эхэнд албан хаагчдын ээлжийн амралтыг "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын даргын тушаалаар батлах бөгөөд хуваарийн дагуу амраана. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй тохиолдолд тухайн албан хаагчид 1.5 сарын албан тушаалын цалинтай тэнцэх мөнгөн урамшуулал олгоно.

### Зургаа. Хүрэх үр дүн

Хөтөлбөр нь зөвхөн байгууллагаас хамааралтай бус албан хаагчдын идэвх оролцоо, мэдлэг чадвар, санал санаачлага, ажлын үр дүнгээс хамааран амжилттай хэрэгжиж үр дүнд хүрнэ.

Бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чадавх сайжирч, тасралтгүй суралцан хөгжиж, иргэдийн хүсэн хүлээж буй эрэлт хэрэгцээнд нийцсэн, үр дүнд чиглэсэн төрийн үйлчилгээний бүтээмж, чанар, хүртээмжийн өндөр төвшинд хүрсэн хамт олон бүрдэнэ.

Төрийн албан хаагчдыг сургаж, хөгжүүлснээр төрийн захиргааны шинэчлэлийг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Төрийн жинхэнэ албан хаагчдыг мэргэшүүлж, тогтвор, суурьшилтай ажиллуулна.

Төрийн албан хаагч нь мэдлэг мэдээлэл олж авснаар ухамсар ёс зүйтэй байж, онол арга зүй, ур чадвар сайжирч, үр бүтээл, идэвх санаачлага, хариуцлагатай байдал дээшилнэ.



"Монгол наадам цогцолбор" орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын даргын даргын 2017 оны 10 сарын 20-ны өдрийн 140 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



## "ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ"-ИЙН ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

/2017-2020/

### НЭГ. АЛБАН ХААГЧДЫН МЭДЛЭГ БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ, МЭРГЭШҮҮЛЭХ:

| №   | Зорилт                                                                                    | Хэрэгжүүлэх арга зам                                                                                                                                                                                                                     | Төсөв /мян.төг/ |             | Төсөв үр дүн                                                                                                                                |
|-----|-------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------|-------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|     |                                                                                           |                                                                                                                                                                                                                                          | Жилд<br>4       | 4 жилд<br>5 |                                                                                                                                             |
| 1   | 2                                                                                         | 3                                                                                                                                                                                                                                        |                 |             | 6                                                                                                                                           |
| 1.1 | Удирдлагын академийн төрийн удирдлагын мэргэшсэн менежер бэлтгэх сургалтууд               | "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-т тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллаж байгаа албан хаагчдаас Удирдлагын академийн 3 сар болон 1.5-2 жилийн захиалгат ангид суралцах шалгаруулалтад оруулж мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх бололцоо олгох |                 |             | Удирдлагын академийн сургалтын төлөвлөгөөний дагуу албан хаагчдын өөрийн хөрөнгөөр хамрагдана. Жилд 2-оос доошгүй албан хаагчийг хамруулна. |
| 1.2 | Төрийн удирдлагын магистрантур болон докторантур, салбарын чиглэлээр аспирантурын сургалт | Дотоод гадаадын магистрантур болон докторантур, салбарын чиглэлээр аспирантур суралцах хугацаанд нь ажлын байрыг хадгалах, ажлын зэрэгцээ суралцах нөхцөл боломжоор дэмжих                                                               |                 |             | Олон улсын төсөл хөтөлбөр, өөрийн хөрөнгөөр санхүүжнэ. Жилд 2-оос доошгүй албан хаагч хамрагдсан байх.                                      |
| 1.3 | Байгууллагад шаардлагатай нарийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх сургалтад хамруулах    | Нарийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд өндөр хөгжилтэй орнуудад суралцуулахад байгууллагын зүгээс шаардлага хангаж буй албан хаагчдыг дэмжиж сургалтад хамруулах                                                                     |                 |             | Байгууллагын төсөв, төсөл хөтөлбөрийн зардал, Олон улсын байгууллагын санхүүжилт. Жилд 1 албан хаагчийг хамруулна.                          |
| 1.4 | Шинэ мэдлэг мэргэшил эзэмшүүлэх                                                           | Байгууллагын ажлын нэн хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах                                                                                                                                          | 1600.0          | 6400.0      | Байгууллагын төсвөөр санхүүжнэ. Жилд 10 хүртэлх албан хаагчийг хамруулна.                                                                   |

|     |                                                                             |                                                                                                                                                                                               |         |         |                                                                                                                      |
|-----|-----------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------|---------|----------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1.5 | Ажлын байран дээр англи хэлний сургалт зохион байгуулах                     | Ажилтнуудын англи хэлний төвшинг нэмэгдүүлэх зорилгоор англи хэлний клуб байгуулах                                                                                                            | 1500.0  | 6000.0  | Байгууллагын төсөв, албан хаагчдын өөрсдийн зардлаар санхүүжнэ. 1 жилд 30-аас доошгүй албан хаагч хамруулна.         |
| 1.6 | "Мэдээллийн цаг"-ийг тодорхой чиглэл зорилго төлөвлөгөөтэй зохион байгуулах | Жил бүр нэгдсэн төлөвлөгөө гарган, хэрэгжүүлж "Мэдээллийн цаг"-ийн үр өгөөжийг дээшлүүлэх Багш нарт урамшуулал олгох.                                                                         | 200.0   | 800.0   | Байгууллагын төсөв, төсөл хөтөлбөр, Олон улсын байгууллагаас санхүүжнэ. Албан хаагчдын мэдлэг боловсрол дээшилнэ.    |
| 1.7 | Дотоод сургалт                                                              | Ажилтнуудын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, харилцааны ур чадвар, байгууллагын соёлыг нэвтрүүлэх, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх, төрөл бүрийн сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх. | 550.0   | 2200.0  | Байгууллагын төсвийн зардлаас санхүүжнэ. Албан хаагчдын мэдлэг боловсрол дээшилнэ.                                   |
| 1.8 | Ажлын туршлага судлах, суралцах үзэсгэлэнд оролцох                          | Гадаадын болон нутгийн захиргааны байгууллагуудын ажлын туршлага, үйл ажиллагааны болон үйлдвэрлэлийн шинэ техник технологитой танилцан, тэдний ажлын амжилтаас нь суралцах                   | 10000.0 | 40000.0 | Байгууллагын төсөв, төсөл хөтөлбөр, Олон улсын байгууллагаас санхүүжнэ. Жилд 5-аас доошгүй албан хаагчдыг хамруулна. |
| Дүн |                                                                             |                                                                                                                                                                                               | 13850.0 | 55400.0 |                                                                                                                      |

### ХОЁР. АЖИЛЛАХ, ТААТАЙ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХ:

| №    | Зорилт            | Хэрэгжүүлэх арга зам             | Төсөв /мян. төг/ |        | Төсөв үр дүн         |
|------|-------------------|----------------------------------|------------------|--------|----------------------|
|      |                   |                                  | Жилд             | 4 жилд |                      |
| 1    | 2                 | 3                                | 4                | 5      | 6                    |
| 2.1. | Ажлын байр, ажлын | Албан хаагчдын ажиллах нөхцөлийг | 500.0            | 2000.0 | Шаардагдах хөрөнгийг |



| нөхцөл                                                     | сайжруулж, тав тухтай орчинг бий болгохын тулд өрөө тасалгааны засварыг цаг тухайд нь хийлгэх, өрөөний агааржуулалт, чийгшүүлэлт, гэрэлтүүлэг, цэвэрлэгээний чанарыг дээшлүүлэхэд анхаарч цэцэгжүүлэх шаардлагатай тохижилтын ажлыг хийх                                                                                                                                                         | 7000.0         | 28000.0        | тухайн жилийн төсөвт тусган хэрэгжүүлнэ.<br>Албан хаагчдын ажиллах нөхцөл сайжирна. |
|------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------|----------------|-------------------------------------------------------------------------------------|
| 2.2. Техник, тоног төхөөрөмжөөр хангах                     | Албан хаагчид сүүлийн үеийн хүчин чадалтай компьютер, принтер, хувилах төхөөрөмж, ноутбук, факсын аппаратаар хангана.<br>Бичиг хэрэг болон зарим албан тушаалтнуудын ажлын онцлог, хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай зургийн аппарат, камер, тектафон, телевизор, магнитофон, сканер, камертай зургийн аппарат зэргээр хангах, техник технологийг зөв зохистой ашиглах сургалтыг зохион байгуулах |                |                | Жил бүрийн төсөвт тусган хэрэгжүүлнэ.<br>Ажилтнуудын ажлын хэрэгцээ хангагдана.     |
| 2.3. Дотоод сүлжээ, интернет ашиглалт                      | Байгууллагын дотоод сүлжээ, интернетийг бүрэн дүүрэн ашиглах, ажил, албандаа сүүлийн үеийн мэдээ мэдээллийг олж авах, мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх                                                                                                                                                                                                                                                | 1000.0         | 4000.0         | Байгууллагын төсвөөс санхүүжнэ.                                                     |
| 2.4. Хууль тогтоомж, эрх зүйн ном сурах бичгийн бүрдүүлэлт | Ажилтнуудаас төрийн албан хаагчдын болон төр захиргааны үйл ажиллагаатай холбоотой судалгаа, шинжилгээ явуулах, бүтээл, ном, товхимол бичих шинэ арга барил туршин нэвтрүүлэх ажлыг дэмжин тусална.<br>Эрх зүйн холбогдол бүхий шаардлагатай хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн болон мэргэжлийн чиглэлээр сүүлийн үед хэвлэгдсэн ном, сурах бичгийн сан бий болгон албан хаагчдад үйлчлэх          | 2000.0         | 8000.0         | Байгууллагын төсвөөс санхүүжнэ.<br>Албан хаагчдын мэдлэг боловсрол дээшилнэ.        |
|                                                            | <b>Дүн</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       | <b>10500.0</b> | <b>42000.0</b> |                                                                                     |

ГУРАВ. НИЙГМИЙН БАТАЛГАА, ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ, ЧӨЛӨӨТ ЦАГИЙГ ЗӨВ БОЛОВСОН ӨНГӨРҮҮЛЭХ:

| №    | Зорилт                               | Хэрэгжүүлэх арга зам                                                                                                                                                                                                                                                          | Төсөв /мян.төг / |         | Төсөв үр дүн                                                                                                                                                                          |  |
|------|--------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------|---------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|
|      |                                      |                                                                                                                                                                                                                                                                               | Жилд             | 4 жилд  | Төсөв үр дүн                                                                                                                                                                          |  |
| 1    | 2                                    | 3                                                                                                                                                                                                                                                                             | 4                | 5       | 6                                                                                                                                                                                     |  |
| 3.1. | Орон сууцны асуудалд дэмжлэг үзүүлэх | Орон сууц авахад нь албан хаагчдын ажилласан хугацаа, ажлын үр дүн, үнэлгээ идэвх санаачлага, амьдралын нөхцөл байдал, зэргийг харгалзан дэмжлэг үзүүлэх<br>Төрөөс зохион байгуулж буй орон сууцны зээлийн хөтөлбөрт орон сууцны зээл авах хүсэлтэй байгаа ажилчдыг хамруулах | 15000.0          | 60000.0 | Байгууллагын төсвөөс санхүүжнэ.<br>Албан хаагчдын амьдрах нөхцөл сайжирна.                                                                                                            |  |
| 3.2. | Зээл                                 | Албан хаагчийн орон сууцны зээл болон хэрэглээний асуудлыг шийдвэрлэхэд холбогдох банк, санхүүгийн байгууллагатай хамтран ажиллаж, цаашид тогтвор суурьшилтай ажиллах ажилтнуудад батлан даалт, холбогдох тодорхойлолтыг гарган өгөх                                          |                  |         | Албаны шаардлагатай баримтыг гаргаж өгч, дэмжлэг үзүүлнэ.<br>Жилд 3-аас доошгүй хүнд дэмжлэг үзүүлнэ.<br>Байгууллагын зүгээс шаардлагатай баримт бичгийг гарган өгч, дэмжлэг үзүүлнэ. |  |
| 3.3. | Газар олголт                         | Албан хаагчдын газар өмчлөлийн судалгааг гаргаж зуслангийн болон хувийн байшин барьж амьдрах сонирхолтой албан хаагчдыг дэмжих, холбогдох хэлтэс албадад уламжлан шийдвэрлүүлэх                                                                                               |                  |         | Хууль тогтоомжид заагдсан хэмжээний газар олгох, хөнгөлөлттэй зээлд хамруулах арга замыг судалж шийдвэрлэнэ.                                                                          |  |
| 3.4. | Эрүүл мэнд                           | Эрүүл мэндийн үзлэг шинжилгээ, оношлогоо хийлгэх, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллах<br>Жил бүр албан хаагчдыг нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгээр оруулж, шинжилгээ хийлгэн, эмчилгээ хийлгэх.                                               | 4000.0           | 16000.0 | Хамтын ажиллагааны хүрээнд шийдвэрлэгдэнэ.<br>Байгууллагын төсөв, төсөл хөтөлбөрийн зардлаас санхүүжнэ.                                                                               |  |



|      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |        |         |                                                                                                                                                                                                                               |
|------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------|---------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|      | <p>боломж олгох</p> <p>Албан хаагчдыг жил бүр витаминжуулж, тэдний эрүүл мэндийг хамгаалах</p> <p>Өндөр настуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах</p> <p>Өндөр настуудад тусламж, дэмжлэг үзүүлэх, шагнаж урамшуулах</p>                                                                                                                                                                                                                                                                                                                  | 100.0  | 400.0   | <p>Жилд 30-40 хүн хамруулна.</p> <p>Байгууллагын төсөв, төсөл хөтөлбөрийн зардлаас санхүүжнэ.</p> <p>Жилд 30-40 хүн хамруулна.</p> <p>Нийгмийн даатгалын хүрээнд шийдвэрлэгдэнэ.</p> <p>Жилд 1-3 өндөр настанг хамруулна.</p> |
| 3.5. | Гэр бүл болох, шинэ хүүхэд мэндлэх                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       |        | 900.0   | <p>Байгууллагын төсөв хөтөлбөр, төслийн зардлаас санхүүжнэ.</p> <p>Жилд 1-3 өндөр настанг хамруулна.</p>                                                                                                                      |
| 3.6. | Биеийн тамир, спорт                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |        | 900.0   | Байгууллагын төсвөөс санхүүжнэ.                                                                                                                                                                                               |
|      | <p>"Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын хамт олны дунд олон төрөлт "спортын тэмцээн" зохион байгуулах</p> <p>"Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын "шигшээ баг"-ийг бүрдүүлэх</p> <p>Цэвэр агаарт ууланд алхах</p> <p>Сайн үйлсийн аян зохион байгуулах</p> <p>Улаанбаатар хоттой танилцах "Тойрон аялал" зохион байгуулах</p> <p>Эрүүл зөв амьдралын хэв маягт суралцах чиглэлээр мэдээ мэдээллийг сургалт сурталчилгаа зохион байгуулах</p> <p>Спортын заалыг хуваарийн дагуу ашиглах</p> <p>Баг тамирчдыг хувцас, хэрэглэлээр хангах</p> | 500.0  | 2000.0  | <p>Байгууллагын дотоод журмын дагуу/</p> <p>Байгууллагын төсвөөс санхүүжнэ.</p>                                                                                                                                               |
|      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |        |         | Байгууллагын төсвөөс санхүүжнэ.                                                                                                                                                                                               |
|      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          | 500.0  | 2000.0  | Албан хаагчдын хамтын ажиллагаа, эрүүл мэнд сайжирч, байгууллагын хэвийн ажиллах нөхцөл бүрдэнэ.                                                                                                                              |
|      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |        |         |                                                                                                                                                                                                                               |
|      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          | 1000.0 | 4000.0  |                                                                                                                                                                                                                               |
| 7.   | Хүүхдийн баяр                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            | 2500.0 | 10000.0 | Байгууллагын төсвөөс санхүүжнэ.                                                                                                                                                                                               |

|      | нөхцөл                                                | сайжруулж, тав тухтай орчинг бий болгохын тулд өрөө тасалгааны засварыг цаг тухайд нь хийлгэх, өрөөний агааржуулалт, чийгшүүлэлт, гэрэлтүүлэг, цэвэрлэгээний чанарыг дээшлүүлэхэд анхаарч цэцэгжүүлэх шаардлагатай тохижилтын ажлыг хийх                                                                                                                                                      |         |         | тухайн жилийн төсөвт тусган хэрэгжүүлнэ. Албан хаагчдын ажиллах нөхцөл сайжирна. |
|------|-------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------|---------|----------------------------------------------------------------------------------|
| 2.2. | Техник, тоног төхөөрөмжөөр хангах                     | Албан хаагчид сүүлийн үеийн хүчин чадалтай компьютер, принтер, хувилах төхөөрөмж, ноутбук, факсын аппаратаар хангана. Бичиг хэрэг болон зарим албан тушаалтнуудын ажлын онцлог, хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай зургийн аппарат, камер, тектафон, телевизор, магнитофон, сканер, камертай зургийн аппарат зэргээр хангах, техник технологийг зөв зохистой ашиглах сургалтыг зохион байгуулах | 7000.0  | 28000.0 | Жил бүрийн төсөвт тусган хэрэгжүүлнэ. Ажилтнуудын ажлын хэрэгцээ хангагдана.     |
| 2.3. | Дотоод сүлжээ, интернет ашиглалт                      | Байгууллагын дотоод сүлжээ, интернетийг бүрэн дүүрэн ашиглах, ажил, албандаа сүүлийн үеийн мэдээ мэдээллийг олж авах, мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх                                                                                                                                                                                                                                             | 1000.0  | 4000.0  | Байгууллагын төсвөөс санхүүжнэ.                                                  |
| 2.4. | Хууль тогтоомж, эрх зүйн ном сурах бичгийн бүрдүүлэлт | Ажилтнуудаас төрийн албан хаагчдын болон төр захиргааны үйл ажиллагаатай холбоотой судалгаа, шинжилгээ явуулах, бүтээл, ном, товхимол бичих шинэ арга барил туршин нэвтрүүлэх ажлыг дэмжин тусална. Эрх зүйн холбогдол бүхий шаардлагатай хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн болон мэргэжлийн чиглэлээр сүүлийн үед хэвлэгдсэн ном, сурах бичгийн сан бий болгон албан хаагчдад үйлчлэх          | 2000.0  | 8000.0  | Байгууллагын төсвөөс санхүүжнэ. Албан хаагчдын мэдлэг боловсрол дээшилнэ.        |
|      | Дүн                                                   |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               | 10500.0 | 42000.0 |                                                                                  |



|      | Боломж олгох                       | Албан хаагчдыг жил бүр витаминжуулж, тэдний эрүүл мэндийг хамгаалах                                     | 100.0  | 400.0   | Жилд 30-40 хүн хамруулна. Байгууллагын төсөв, төсөл хөтөлбөрийн зардлаас санхүүжнэ. Жилд 30-40 хүн хамруулна. Нийгмийн даатгалын хүрээнд шийдвэрлэгдэнэ. Жилд 1-3 өндөр настанг хамруулна. |
|------|------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------|--------|---------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|      |                                    |                                                                                                         |        |         |                                                                                                                                                                                            |
| 3.5. | Гэр бүл болох, шинэ хүүхэд мэндлэх | Өндөр настнуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах                                                         |        |         |                                                                                                                                                                                            |
|      |                                    | Өндөр настнуудад тусламж, дэмжлэг үзүүлэх, шагнаж урамшуулах                                            | 900.0  | 3600.0  | Байгууллагын төсөв хөтөлбөр, төслийн зардлаас санхүүжнэ. Жилд 1-3 өндөр настанг хамруулна.                                                                                                 |
| 3.6. | Биеийн тамир, спорт                | Шинэ гэр бүл болсон болон шинээр хүүхэд төрүүлсэн гэр бүлд санхүүгийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх        | 900.0  | 3600.0  | Байгууллагын төсвөөс санхүүжнэ. /Байгууллагын дотоод журмын дагуу/                                                                                                                         |
|      |                                    | "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын хамт олны дунд олон төрөлт "спортын тэмцээн" зохион байгуулах       | 500.0  | 2000.0  | Байгууллагын төсвөөс санхүүжнэ.                                                                                                                                                            |
|      |                                    | "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын "шигшээ баг"-ийг бүрдүүлэх                                          |        |         | Байгууллагын төсвөөс санхүүжнэ.                                                                                                                                                            |
|      |                                    | Цэвэр агаарт ууланд алхах                                                                               |        |         |                                                                                                                                                                                            |
|      |                                    | Сайн үйлсийн аян зохион байгуулах                                                                       |        |         |                                                                                                                                                                                            |
|      |                                    | Улаанбаатар хоттой танилцах "Тойрон аялал" зохион байгуулах                                             | 500.0  | 2000.0  | Албан хаагчдын хамтын ажиллагаа, эрүүл мэнд сайжирч, байгууллагын хэвийн ажиллах нөхцөл бүрдэнэ.                                                                                           |
| 3.7. | Хүүхдийн баяр                      | Эрүүл зөв амьдралын хэв маягт суралцах чиглэлээр мэдээ мэдээллийг сургалт сурталчилгаа зохион байгуулах |        |         |                                                                                                                                                                                            |
|      |                                    | Спортын заалыг хуваарийн дагуу ашиглах                                                                  |        |         |                                                                                                                                                                                            |
| 3.7. | Хүүхдийн баяр                      | Баг тамирчдыг хувцас, хэрэглэлээр хангах                                                                | 1000.0 | 4000.0  |                                                                                                                                                                                            |
|      |                                    | Хүүхдийн баярыг тохиолдуулан албан хаагчдын хүүхдүүдийн дунд уралдаан                                   | 2500.0 | 10000.0 | Байгууллагын төсвөөс санхүүжнэ.                                                                                                                                                            |

|     |                                                                     |                                                                                                                                                                   |         |          |  |                                                                                                                     |
|-----|---------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------|----------|--|---------------------------------------------------------------------------------------------------------------------|
|     |                                                                     | тэмцээн зохион байгуулах, бэлэг өгөх                                                                                                                              |         |          |  | Холбогдох албан бичгээр санал хүргүүлж, хамтран ажиллана.                                                           |
| 8.  | Ногоо тарих                                                         | Ажилтнуудын хүүхдүүдийг Олон улсын Найрамдал зуслан, бусад зусланд амруулахад дэмжлэг үзүүлэх                                                                     |         |          |  | Холбогдох яам, агентлаг, хөтөлбөрт хамтруулна.                                                                      |
| 9.  | Амралт зугаалга                                                     | Төрийн албан хаагчийн өрхийн орлогыг зохих хэмжээгээр нэмэгдүүлэх зорилгоор туслах аж ахуй эрхлэх, ногоо тарихад нь газрын асуудлыг шийдвэрлэхэд тусалцаа үзүүлэх | 1500.0  | 6000.0   |  | Байгууллагын төсөв, хөтөлбөрт төслийн зардлаас санхүүжнэ.                                                           |
| 10. | Байгууллагын гадаад, дотоодын үйл ажиллагаанд албан хаагчдын ороцоо | Ажилтнуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор өвөл зуны улиралд хамт олноороо байгалийн үзэсгэлэнт газруудаар аялах, явган аялал зохион байгуулах   |         |          |  | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаар дамжуулан Нийслэлийн Засаг даргын Захирамжаар шаардагдах зардлыг шийднэ. |
|     | Дүн                                                                 |                                                                                                                                                                   | 26900.0 | 107600.0 |  | Жилд 3-аас доошгүй хүүхэд хамруулах/                                                                                |

ДӨРӨВ. ЦАЛИН ХӨЛС, ШАГНАЛ, УРАМШУУЛАЛ:

| №  | Зорилт                                                               | Хэрэгжүүлэх арга зам                                                            | Төсөв /мян. төг / Жилд | Төсөв үр дүн 4 жилд | Хэрэгжүүлэх арга зам                                            |
|----|----------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------|------------------------|---------------------|-----------------------------------------------------------------|
| 1  | 2                                                                    | 3                                                                               | 4                      | 5                   | 6                                                               |
| 1. | Шагнал, урамшуулал                                                   | Албан хаагчдын ажлын үр дүнгийн үнэлгээг үндэслэн хагас бүтэн жилээр урамшуулах | 6000.0                 | 24000.0             | Байгууллагын төсвөөс санхүүжнэ. /Байгууллагын даргын тушаалаар/ |
|    | Хариуцсан салбарынхаа тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд бодитой |                                                                                 | 1000.0                 | 36000.0             | Байгууллагын төсвөөс санхүүжнэ.                                 |



|  |                                                                                                                                            |                |                 |                                                 |
|--|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------|-----------------|-------------------------------------------------|
|  | хувь нэмэр оруулсан албан хаагчдыг<br>шагнаж урамшуулах                                                                                    |                |                 | Жилд 1-ээс доошгүй албан<br>хаагчийг хамруулна. |
|  | Тэмдэглэлт баяр ёслол, ойн баяраар<br>ажлын үр дүнгээрээ шалгарсан албан<br>хаагчдын төрийн болон нийслэл,<br>салбарын шагналд тодорхойлох | 500.0          | 2000.0          | Байгууллагын төсвөөс<br>санхүүжнэ.              |
|  |                                                                                                                                            | 7500.0         | 30000.0         | Жилд 1-ээс доошгүй албан<br>хаагчийг хамруулна. |
|  | <b>Дүн</b>                                                                                                                                 | <b>58750.0</b> | <b>235000.0</b> |                                                 |
|  | <b>Нийт дүн</b>                                                                                                                            |                |                 |                                                 |